



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

А.Мөнхцэцэг

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.1 Зөвлөмж.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2021.02.25 № 78

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42,812,940.00</u>	<u>45,178,568.50</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	42,812,940.00	45,178,568.50
351	Түүхий эд материал	258,000.00	198,000.00
35130	Эм боох материал	258,000.00	198,000.00
354	Хангамжийн материал	42,554,940.00	44,980,568.50
35410	Бичиг хэргийн материал	2,823,240.00	2,862,345.00
35420	Аж ахуйн материал	39,167,700.00	41,268,700.00
35440	Түлш, шатах тослох материал	564,000.00	849,523.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,489,076,592.40</u>	<u>2,412,135,168.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,489,076,592.40	2,412,135,168.00
392	Биет хөрөнгө	2,482,346,592.40	2,405,405,168.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,273,315.90	-71,617,553.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,949,534.00	148,951,534.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,790,003.83	-33,001,519.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,190,016.73	-28,750,698.61
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,744,084.04	-20,571,073.16
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,531,889,532.40</u>	<u>2,457,313,736.50</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,531,889,532.40</u>	<u>2,457,313,736.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,531,889,532.40	2,457,313,736.50
512	Хуримтлагдсан үр дүн	2,326,597,557.78	2,252,021,761.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-74,575,795.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,531,889,532.40</u>	<u>2,457,313,736.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,855,990,360.50</u>	<u>478,025,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>2,367,864,860.50</u>	<u>2,638,500.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	2,367,864,860.50	2,638,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,367,864,860.50	2,638,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,367,864,860.50	2,638,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>69,375,400.00</u>	<u>72,258,100.00</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,750,100.00	403,128,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,375,400.00	72,058,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,375,400.00	72,058,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>520,682,558.99</u>	<u>552,600,995.90</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>520,682,558.99</u>	<u>552,600,995.90</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,387,311.31	523,116,767.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,398,631.32	317,212,356.52
210101	Үндсэн цалин	172,808,331.32	208,535,292.26
210102	Нэмэгдэл	95,695,700.00	83,577,077.37
210104	Урамшуулал	30,398,200.00	25,099,986.89
210105	Гэрээт ажлын хөлс	13,496,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,329,800.00	43,016,100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,424,300.00	30,270,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,226,400.00	3,186,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,581,100.00	2,549,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,300.00	637,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,452,700.00	6,372,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,975,403.70	39,317,511.72

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	8,540,207.00	7,239,246.22
210302	Түлш, халаалт	41,968,996.70	25,729,565.50
210303	Цэвэр, бохир ус	13,466,200.00	6,348,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,092,200.00	2,306,245.00
210401	Бичиг хэрэг	85,400.00	500,500.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	510,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,500.00	338,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	72,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,899,300.00	883,295.00
2105	Нормативт зардал	33,397,100.00	28,845,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,294,700.00	208,900.00
210502	Хоол, хүнс	30,872,400.00	28,265,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,000.00	371,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,244,200.00	7,880,000.00
210604	Урсгал засвар	1,244,200.00	7,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	85,400.00
210702	Дотоод албан томилолт	128,000.00	85,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,828,360.00	1,622,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,828,360.00	1,622,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,993,616.29	82,830,824.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,406,680.62	984,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,505,200.00	2,902,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	33,081,735.67	78,943,424.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,295,247.68	29,484,228.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,295,247.68	29,484,228.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,335,307,801.51	-74,575,795.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,434,160.36	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,434,160.36	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,434,160.36	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,333,873,641.15	-74,575,795.90

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	7,183,955.16	00.00	212,475,929.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	7,183,955.16	00.00	212,475,929.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,326,597,557.78	00.00	2,531,889,532.40
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,326,597,557.78	00.00	2,531,889,532.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,326,597,557.78	00.00	2,531,889,532.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	00.00	00.00	00.00	00.00	00.00

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-74,575,795.90	00.00	-74,575,795.90
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,252,021,761.88	00.00	2,457,313,736.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>488,125,500.00</u>	<u>475,386,700.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,125,500.00	475,386,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,750,100.00	403,128,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,375,400.00	72,058,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,375,400.00	72,058,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>487,911,300.00</u>	<u>475,386,700.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,911,300.00	475,386,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,616,052.32	445,902,471.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,743,309.32	317,212,356.52
210101	Үндсэн цалин	174,153,009.32	208,535,292.26
210102	Нэмэгдэл	95,695,700.00	83,577,077.37
210104	Урамшуулал	30,398,200.00	25,099,986.89
210105	Гэрээт ажлын хөлс	13,496,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,329,800.00	43,016,100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,424,300.00	30,270,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,226,400.00	3,186,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,581,100.00	2,549,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,300.00	637,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,452,700.00	6,372,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,103,183.00	39,603,035.22
210301	Гэрэл, цахилгаан	8,540,207.00	7,239,246.22
210302	Түлш, халаалт	42,290,976.00	26,015,089.00
210303	Цэвэр, бохир ус	13,272,000.00	6,348,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,700,400.00	1,905,850.00
210401	Бичиг хэрэг	133,300.00	420,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,040,300.00	510,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,500.00	338,800.00
210404	Ном, хэвлэл	75,800.00	96,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,343,500.00	538,900.00
2105	Нормативт зардал	33,740,850.00	30,226,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,069,700.00	148,900.00
210502	Хоол, хүнс	29,751,150.00	28,265,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	920,000.00	1,812,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	8,750,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	8,750,000.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	85,400.00
210702	Дотоод албан томилолт	128,000.00	85,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,852,610.00	1,427,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,852,610.00	1,427,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,517,900.00	3,675,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,517,900.00	2,782,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,295,247.68	29,484,228.26

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,295,247.68	29,484,228.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	214,200.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	214,200.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,186,700.00	445,702,471.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,186,700.00	445,702,471.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,186,700.00	445,702,471.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,198,000.00	317,212,356.52
210101	Үндсэн цалин	243,683,400.00	208,535,292.26
210102	Нэмэгдэл	53,211,100.00	83,577,077.37
210104	Урамшуулал	23,303,500.00	25,099,986.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,016,100.00	43,016,100.00
210201	Тэтгэврийн даатгал	30,270,700.00	30,270,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,186,300.00	3,186,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,549,100.00	2,549,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	637,200.00	637,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,372,800.00	6,372,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,308,100.00	39,603,035.22
210301	Гэрэл, цахилгаан	6,604,900.00	7,239,246.22
210302	Түлш, халаалт	39,453,200.00	26,015,089.00
210303	Цэвэр, бохир ус	17,250,000.00	6,348,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,723,500.00	1,705,850.00
210401	Бичиг хэрэг	420,700.00	420,500.00
210402	Тээвэр, шатахуун	525,000.00	510,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	341,800.00	338,800.00
210404	Ном, хэвлэл	97,100.00	96,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	338,900.00	338,900.00
2105	Нормативт зардал	32,970,600.00	30,226,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,900.00	148,900.00
210502	Хоол, хүнс	31,009,300.00	28,265,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,812,400.00	1,812,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,750,000.00	8,750,000.00
210604	Урсгал засвар	8,750,000.00	8,750,000.00
2107	Томилолт, зочны зардал	117,000.00	85,400.00
210702	Дотоод албан томилолт	117,000.00	85,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,427,100.00	1,427,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,427,100.00	1,427,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3676300.00	3675800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,783,300.00	2,782,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	475,186,700.00	475,186,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	403,128,600.00	403,128,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,128,600.00	403,128,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,058,100.00	72,058,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	72,058,100.00	72,058,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18
620003	Үйлчлэх ажилтан	13	13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	200000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үндсэн зорилт чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Түвшинширээ сумын ТТЗ-ийн харьяа байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 520.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.6 сая төгрөг буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	42.8	45.2	2.4
Үндсэн хөрөнгө	2,489.1	2,412.1	-77.0
Нийт хөрөнгө	2,531.9	2,457.3	-74.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,531.9	2,457.3	-74.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,531.9	2,457.3	-74.6

- Бараа материалын дансны үлдэгдэл 45.2 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.4 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авсан нь бараа материал данс өсөхөд нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,412.1 сая төгрөг болж, 77.0 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,377.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгаа байгууламж буюу үнэ төлбөргүй хүлээн орлого хүлээн авсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 31.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн цалин, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал, урсгал засвар, бараа ажил үйлчилгээний бусад зардлын данс байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 39.3 сая төгрөгөөр бууруулж 572.6 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 126.9 сая төгрөгөөр нэмэгджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 445.7 сая төгрөгийг улсын төсвөөс баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 475.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 445.7 сая төгрөг зарцуулж 29.5 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Ковид19 цар тахлын өвчлөлтэй холбогдуулан дээд газраас /яамнаас/ 0.2 сая төгрөгийн эм бэлдмэлийн зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 118 мэдээлэл, 448.7 сая төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Түлш, халаалтын зардлаас нүүрс тээвэрлэлтийн хөлс олгохдоо МУ-ын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 374 тоот тушаалаар баталсан тарифт хэмжээнээс өндрөөр бодож, Амгалан тал ХХК-д 1.4 сая төгрөг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсанд зөвлөмж, зөрчлийг арилгах 1 зөвлөмжийн биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	1.4	1	1.4	-	-	-
Нийт дүн	1	1.4	1	1.4	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, шилэн данс, үндсэн хөрөнгийн зардалтай холбоотой 2 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 АЛБАН ШААРДЛАГА

Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой үнэлж, тоолоогүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй, бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй, материалыг нэр төрөл, тоо ширхгээр орлого авч зарлага болгоогүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1¹, 72.4.2², 72.4.4³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6⁴, 4.1⁵, 13.1⁶, 13.6⁷, 13.7⁸, 20.2.3⁹ дахь заалттай нийцэхгүй, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 29 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 448.7 сая төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих

¹ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

² тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

³ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

⁴ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

⁵ Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:

⁶ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

⁸ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁹ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн	3	40.0	-	-	-	-	1	40.0	2	-